

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234710

**УЛАМЖЛАЛТ ОРЧУУЛГЫН ХЭЛНИЙ ОЙРОЛЦОО ҮГС,
УТГА, ТҮҮХЭН ОНЦЛОГ**

О.Дэмчигмаа

Товчлол: Нэг зохиолын олон орчуулга бол ойролцоо үг үүсэх эх үндэс болно. Үгийн сангийн гол нэгжийн нэг болох ойролцоо үгс утгын нарийн өнгө аясыг илэрхийлж, найруулгыг зөв оновчтой, утга төгөлдөр, уран яруу болгоход ихээхэн үүрэгтэй. Ойролцоо үг үүсэх хэд хэдэн тохиолдол байдаг бөгөөд энд нэг зохиолын олон орчуулгын хүрээнд ойролцоо үг хэрхэн үүсэж буй байдлыг “Субашид”-ын орчуулгуудад тулгуурлан 1. хүндэтгэлийн үг + ерийн үг, 2. утга зохиолын хэлний үг+ нутгийн аялгууны үг, 3. илт өгүүлэх нэр + ерийн нэр, 4. хуучирсан болон түүхэн үг + шинэ үг, 5. уугал үг + уугал үг, 6. уугал үг + харь үг, 7. харь үг + харь үг, 8. хэлц үг + хэлц үг хэмээн авч үзэв. Чингэхдээ зарим хуучирсан хийгээд түүхэн үг, харь үгийн гарал ирэл, утгын хувьсал, хэрэглээг тодорхой жишээгээр тайлбарлахын сацуу үгийн давтамжид үндэслэн бусад судар сурвалж, бичгийн дурсгал, толь бичгүүдээс мөшгөн тодрууллаа.

Түлхүүр үг: уламжлалт орчуулга, орчуулгын хэл, ойролцоо үг, үгийн утга, түүхэн онцлог

Монгол хэлний үг хэллэгийн үүсэл гарал, үүх түүх, үгийн сангийн утгын хувьсал тэргүүтнийг цөөн хэмээлгүй баримт дурсгалд түшин тодруулж гаргах нь олон талын хэрэгтэй төдийгүй ингэж шүүн үзэхэд хэдэн зууны зааг завсартай нэг зохиолын хэд хэдэн орчуулгыг харьцуулан үзэх сонин бөгөөд чухал юм. Ийм дурсгалд “Субашид”-ын үе үеийн монгол орчуулга чухал байр суурь эзэлнэ. Эдгээр нь сурвалж судлал, орчуулгын судлал төдийгүй хэл шинжлэл, түүхэн үгийн сангийн судлалд тун үнэ цэнтэй хэрэглэгдэхүүн болно.

Аливаа хэлний үгийн сан баяжин хөгжих олон арга зам байдаг бөгөөд орчуулгын хэлний хүрээнд үзвэл эх зохиолын нэг үгийг дуун хөрвүүлэгч нар өөр өөрөөр оноон буулгаснаар ойролцоо үгсийг үүсгэхийн зэрэгцээ харь хэлний үг нэвтрэн идээшиж, утга хэрэглээний хувьд хувьсан өөрчлөгдөж үгийн санг өргөжүүлэн тэлж байдаг байна. Түүнчлэн зарим харь үг уугал үг мэт болж танигдахааргүй болсон байх нь олонтоо.

Үгийн сангийн нэгэн гол нэгж болох ойролцоо үгс олон талтай баялаг бөгөөд утгын нарийн өнгө аясыг илэрхийлж, найруулгыг яруу тансаг болгоход ихээхэн үүрэгтэй билээ. Ялангуяа орчуулгын үг хэллэг, найруулгыг зөв оновчтой, уран яруу, утга төгөлдөр болгоход нэн тустай. Үүнтэй уялдуулан, орчуулгын хэлний ойролцоо үгс хийгээд тэдгээрийн утгын хувьсал, хэрэглээний талаар “Субашид”-ын монгол орчуулгуудад тулгуурлан, цуваа цагийн үүднээс тодруулан өгүүлье.

Ойролцоо үг үүсэх тохиолдлуудыг дурдвал: хуучин үг шинэ үгтэй, утга зохиолын хэлний үг нутгийн аялгууны үгтэй, уугал үг уугал үгтэй, хүндэтгэлийн үг ерийн үгтэй, бичгийн үг ярианы үгтэй, уугал үг харь үгтэй, хэлц үг ерийн үгтэй, цээрлэсэн үг тухайн зүйлийн нэртэйгээ, бүтцийн хувьд дан үг хоршоо үгтэй, холбоо үг дан үгтэй, дан үг өвөрмөц хэлцтэй, дан үг хэвшмэл хэлцтэй, хоршоо үг өвөрмөц хэлцтэй, хоршоо үг хоорондоо, нийлэмж үг хоорондоо, хэвшмэл хэлц хоорондоо, мөн авианы хувирлын дүнд ойролцоо үг үүсэх зэрэг болно.

“Субашид”-ын монгол орчуулгуудын тухайд эх зохиолын нэг үгээс ойролцоо үгс үүсэж буй тохиолдлыг дараах байдлаар авч үзнэ.

- 1. хүндэтгэлийн үг + ерийн үг
- 2. утга зохиолын хэлний үг+ нутгийн аялгууны үг
- 3. илт өгүүлэх нэр + ерийн нэр
- 4. хуучирсан болон түүхэн үг + шинэ үг
- 5. уугал үг + уугал үг
- 6. уугал үг + харь үг
- 7. харь үг + харь үг
- 8. хэлц үг + хэлц үг

1. *Хүндэтгэлийн үг ерийн үгтэй:*

Энэ төрлийн ойролцоо үгс нэг зүйл, нэг утгыг илэрхийлэх боловч хэл найруулгын хувьд ялгаатай юм. Тухайлбал, *хамгийг айлдагч-хамгийг мэдэгч*.

**10. de ltar rgyun du spyad pa yis
myur du thams cad mkhyen par ‘gro**

СГ.nasuda teyin kü yabubasu ele
üter *qamuy-i medegči* bolumui

ЗБ. tere metü ürgül...ide üyiledüqsen-yēr
ötör *xamug-i medeqči* bolxu

МГ.tere metü ürgül...ide kičiyegsen kücü-ber
üdtür böged *qamuy ...üyil-i ayiladyči* boluyu.

ДГ. tere metü ürgül...ide kičiyegsen kücü-ber
üdtür böged *qamuy ...üyil-i ayiladyči* boluyu.

ЦГ. ke...iyede tere metü surulča...u yabubasu
ketürkei *qamuy-i medegči* bolqu boluyu.

СР. ke...iyede tere metü surulča...u yabubasu
ketürkei *qamuy-i medegči* bolqu boluyu.

Төвөд хэлний “*mkhyen pa-мэдэх, мэдэгч*” хэмээх үгээс “мэдэгч”, “айлдагч” гэж ойролцоо үг үүсжээ. “Айлдах” гэдэг бол бичгийн хэлэнд “мэдэх”-ийн хүндэтгэлийн утга илэрхийлнэ.

2. *Утга зохиолын хэлний үг, нутгийн аялгууны үгтэй:* Үүнийг үнэмлэхүй ойролцоо үг (Монгол хэл судлал 2022:161) гэж үзэх нь бий. **387** дугаар бадагт дахь ‘*dral*’ хэмээх үгээс дараах ойролцоо үгс үүсэж байна.

- Тө.** longs spyod ha cang ‘phel drags na
de la rgud pa shin tu nye
chu yis shin tu gang ba yi
rdzing bu stong ngam yang na ‘*dral*
- СГ.**ed-i asuru ülem...i quriyabasu
Tere kümün üter böged singtaran bui
Usu-bar masi dügürügsen nayur
Debülün ba es-e bögesü *balbaramui*
- ЗБ.** ...iryalang neng yeke delgerekülē
Töün-dü buural maši šidar
Usun-yēr maši döüreqsen
Köb barixu buyu ese bögösü *cumaraxu*
- МГ.**edlel inu ketürkey-e arbi...i...u
usu tere kümün bayuraqu masi oyira bolumui.
usun-iyar oγuyata dügürügsen čögürüm
qoγusun ba esebesü *tamtaraqu* boluyu.
- ДГ.**edlel-iyen ketürkey-e arbidqa...u abasu
tere kümün bayuraqu masi oyira bolumui.
usun-iyar oγuyata dügürügsen čögürüm
qoγusun ba esebesü *tamtaraqu* boluyu.
- ЦГ.**ed mal terigüten yayum-a neng ösbesü
egüri bayural (45b) ügei batu toytaqu yerü berke
ergi ba qotuyur γa...ar-a usu neng dügürbesü
ebdere...ü urusqu ba esebesü sirgi...ü qataqu metü
- СР.**asuru edlel arbidqu neng ketürebesü
adaγ-tayan tegün-dür ügegürel masi oyira
ali usun-iyar bilqayitala masi degürügsen čögerem
adaγ-tayan sirgekü buyu esebesü *sadaramui*

Төвөд эхийг үгчилбэл:

төгс эдлэл хэтэрхий арвидваас
түүнд доройтол машид ойр
усаар машид дүүрсэн
цөөрөм хоосрох буюу эс бөгөөс эвдрэх

Үүний утга нь *хэт их эд баялагтай хүн санаа амар сайхан жаргахад бэрх, хулгай дээрэм, зээл гуйлга зэрэгт илүүтэй нэрвэгдэж доройтдог. Зүйрлэвэл горхи цөөрөм усаар хэтэрхий дүүрвэл халих буюу эсвэл эвдрэн урсаж үгүй болно* гэсэн санаа ажээ. Эл бадаг дахь ‘*dral*’ буюу *цуцлах, хагалах, эвдэх* гэсэн утга бүхий үгийг орчуулагч нар ойролцоо үгээр онооцгоосон нь:

Сономгара *balbaramui* гэжээ. “*Балбарax*” гэдэг *хэмхрэх, няцрах, хагарах, урагдах* (Цэвэл 2007:70; Болд нар 2007:1.230; Норжин 1999:899) хэмээсэн утгатай үг юм.

Зая бандида **cumaraxu** хэмээн ойрад нутгийн аялгууны үгээр оноосон бөгөөд эл үг халх аялгууны “цөмрөх”-тэй адил утгатай.

Мэргэн гэгээн **tamtaraq** гэсэн нь элэгдэж урагдах, эвдрэн сүйдэх гэсэн үндсэн утгатайн дээр хоосорч доройтох, үгүй болох гэсэн шилжсэн утгатай юм.

Цахар гэвш **ebdere...ü urusqu** гэж энгийн олонд тун ойлгомжтой ерөнхий утгатай үгээр буулгажээ.

Сумадираднаа **sadaramui** гэсэн нь шингэн, үйрмэг зүйлийн олгойдон гоожих, олон тийшээ гэнэт асгарах (Болд нар 2007:3.497) -ыг хэлэх тул тун оновчтой оноосон байна.

Ийн төвөд хэлний **‘dral** хэмээх үгийн орчуулгаас *балбарах, цумрах, тамтрах, эвдэрч урсах, садрах* зэрэг ойролцоо үгс үүсжээ. Энэ бол бичгийн хэлний үг нутгийн аялгууны үгтэй ойролцоо үг үүсгэж буй хэрэг юм.

3. *Хэлц үг ерийн үгтэй буюу илт өгүүлэх нэр ерийн нэртэй:*

шавраас төрсөн-лянхуа, огторгуйд нисэгч-гарди-огторгуйд халигч гэх мэт.

122. ‘dam skyes ‘dam gyis ma gos la

de nyid nyi mas rtag tu skyong

СГ. sibara ülü qaldaqu **lingqu-a-yi** [lingqu-a-yi]

naran qola-ača öskeyü.

ЗБ. šabar-ēce töröqsön-dü šabar ülü xaldan

töüni naran nasun tedkükü

МГ. lingqu-a-dur sibar-iyar ülü qaldamui

lingqu-a-yi naran iyar masi tedkümüi

ДГ. lingqu-a-dur sibar-iyar ülü qaldamui

lingqu-a-yi naran iyar masi tedkümüi

ЦГ. ü...esküleng tü čečeg šibar dotur-a urγubaču šibar ülü nayalduqu

üsüd qola bayiγsan naran-iyar tegüni ösken delgeregülkü

СР. onča sibar-ača urγuγsan **lingqu-a**-dur sibar ülü nayaldum.

oytarγui-du qola bayiγsan naran tegüni ösken delgeregülüü.

Лянхуа цэцэг бол намаг балчигт ургадаг боловч шавар, хир буртаг огт наалддаггүй хиргүй ариун, үзэсгэлэнт цэцэг учир Сономгара “шавар үл халдах”, Цахар гэвш “шавар үл наалдах” гэж, Зая бандида төвөд эхийг үгчлээд шавраас төрсөн” хэмээсэн нь лянхуан илт өгүүлэх нэр бөгөөд Мэргэн гэгээн, Дана-гийн гэгээн, Сумадираднаа нар лянхуа гэх хятад үгээр оноосон нь илт өгүүлэх нэр ерийн нэртэй ойролцоо үг үүсгэжээ.

4. Хуучирсан болон түүхэн үг шинэ үгтэй:¹

5. **ri dwags rgyal bo bkres pa na**

glang chen spyi bo myur du ‘gems

СГ. görüged-ün qan arslan ölüsbesü ber

...ayan-u **ekin** mön degere qayaluyu

ЗБ. görösüni xān ölösküle

zāni **oroī** ötör xayalxu

МГ. görüged-ün qayan ölüsbesü y-a

¹ Энд шинэ үг гэж хожуу хэрэглээнд орж, орчин цагийн монгол хэлнээ идэвхтэй хэрэглэгдэж буй үгийг хамааруулав.

...ayan бүкүй-ийн *tarikin*-и qayalum.

ДГ. görüged-ün qayan ölüsbesü

...ayan бүкүй-ийн *tarikin*-и qayalum.

ЦГ. ariyatan-u qayan arslan ölüsbesü ele

asuru türgen-e (3a) ...ayan-u *toluyai*-yi qayaluyu.

СР. ariyatan-u qayan arslan ölüsbesü ele

asuru türgen-e ...ayan-u *toluyai*-yi qayaluyu.

Дээрх жишээнээс *glang chen spyi bo* хэмээх төвөд үгийг орчуулсан байдлыг үзвэл сонирхолтой байна. *spyi bo* бол “орой” гэсэн утгатай. Зая бандида эл үгээр нь оноосон бөгөөд эдүгээ толгойн дээд тал хийгээд аливаа юмны дээд, түрүү хэсгийг заадаг.

Сономгара ...*ayan-u ekin* гэж буулгажээ. Дундад үеийн монгол хэлэнд толгойг “эхин” гэж хэлдэг байсан нь бичгийн дурсгалуудаас тодорхой харагддаг. Эдүгээ дагуур хэл болон зарим нутгийн аялгуунд мөн “эхин” (Энхбат 1985:21) гэж ярьдаг бол дунсян хэлэнд “тэргүүн, орой” (Бөх нар 1986: 322), монгол хэлэнд “толгой” (Цэнгэлтэй 1988:21) гэж ярьдаг байна. Эртний монгол хэлнээ толгой, түрүү, ахлагч гэсэн утгатай байжээ.

Мэргэн гэгээн ...*ayan бүкүй-ийн тарикин* гэжээ. Толгойг бас тархи гэх боловч юуны түрүүнд гол төлөв гавлын ясны дотор байрлах мэдрэлийн тогтолцооны төв эрхтэн гэдгээр ойлгодог. Харин толгойг “хагарах, хагалах” гэдэг үгтэй холбон ярихдаа ихэвчлэн “тархи хагарах, тархи хагалах” гэж ярьдаг билээ.

Цахар гэвш, Сумадираднаа нар ...*ayan-u toluyai* гэж оноожээ. Ер эрт үедээ “толгой” хэмээх үгийг хэрэглэдэггүй, оронд нь “эхин, орой” гэх үгсийг зардаг байсан нь харагддаг. Орчин цагийн монгол хэлэнд “эхин, орой” зэрэг үгсийн утга шилжиж, аливаа юмны дээд тал, түрүүг заах болсон байна. Үгсийн давтамжийг хүснэгтээр харуулбал дараах мэт.

Хүснэгт 1. *spyi bo*

	Давтамж	Төвөдөөр	Сономгара	Зая бандида	Мэргэн гэгээн	Дана гэгээн	Цахар гэвш	Сумади раднаа
ekin	3	<i>spyi bo, mgo</i>	5, 277, 418	-	-	-	-	-
oroi	41		6		9	7	6	8
tariki	2				1	1		
toluyai	32			6	5	5	6	9

Орой хэмээх үг мөргөлийн шүлэгт 5, төгсгөлийн шүлэгт 1 удаа мөн тохиолдож буй. Энэ мэтчилэн

γarqu², deyilkü,

doriγun, ečin-e, dalda

jonturuγ, xaldabur, uršiq, qoorlal, gem

γarin turuuni orom tuyurin-u orom üker-ün giskigsen mör üker-ün tayurai-yin γarin

buduγu mungxaq, mungqay teneg зэрэг үгсийг дурдаж болно.

² Ялгуусах, ялан дийлэх гэсэн утгатай.

5. Уугал үг уугал үгтэй: *егүүтгэлдэх, арилжих, ээлжлэх, улиран сэлгэх*

253.bde dang sdug bsngal thams cad kyang

dbyar dgun bzhin du **brje bar** ‘gyur

СГ. ...obalang ...iryalang бүгүдегер

ebül ...un metü **yegüdkeldükün** bui

ЗБ. amuyūulang zobolong xamuq čü

öböl zun metü **aril...ixu** boluyu

МГ, ДГ. ...iryalang ba ...obalang-ud qoyayula бүгүде

ebül ...un-u yosuγar kü **egel...ilen** bolumui

ЦГ. orčilang-dur yerü ...iryalang ...obalang qoyayula

oyuyata ...un ebül metü **egel...igseger** bayiqu

СР. orčilang-dur yerü ...iryalang ...obalang qoyayula

ularin selgügči ...un ebül qoyar metü bolai.

yegüdkeldü- Дундад эртний монгол хэлэнд “*солих, ээлжлэх, сэлгэх*” гэх мэт утгатай байжээ. “МНТ”-ны 192, 203, 205, 227, 229, 248, 278 дугаар зүйлүүдэд “**yegüdkе-**” хэмээх язгуур “*солилцох, ээлжлэх*” гэсэн утгыг илэрхийлж буй. Тухайлбал, 192 дугаар зүйлд “...*qurban söni qurban üdür kesik üdür-iyen dawuscu mün-gü yosu’ar qurban söni qonolduju ye’ütgeldüjü söni kebte’ül atuqai...*” (Rachewilts 1972: 100) хэмээхэд “*егүүтгэлдэж*” гэдэг бол “*солилцож*” гэсэн утгыг илэрхийлж байгаа нь тодорхой харагдана. Харин сүүлийн үед уг утга орхигдсон бөгөөд одоо “сүйтгэх, бүрэлгэх, нас нөгчих” гэдэг шилжсэн утгаар ойлгогдох болжээ. Эдүгээ уг үгийн үндсийг “*юүлэх*” гэдэг үгнээс олж харж болно. Жишээлбэл, нэг савнаас нөгөөд сольж хийх, унаа морио сольж унах гэхэд “*юүлэх*” хэмээн ярилцдаг билээ. (Дэмчигмаа 2013:56) Энэхүү үгтэй арилжих, ээлжлэх, улиран сэлгэх зэрэг ойролцоо үг үүсжээ.

6. Уугал үг харь үгтэй:

Уугал үг харь үгтэй ойролцоо утга үүсгэж буй хийгээд харь үгэнд шахагдан хуучирсан үг болж үлдсэн тохиолдол цөөнгүй бий.

371, 275 дугаар бадагт:

371.longs spyod nyams pa’i sa phyogs spang

mi ‘phrog na yang **brnya skyis ‘joms**

Үг. Төгс эдлэл доройтсон газар зүгийг тэвч

Эс булааваас **зэлээр даргах**

СГ. Ed-i barayuluγči γa...ar-a

Es-e ber bulibasū **aysuyad barayu**

ЗБ. **erlige-bēr doroyituulxu,**

МГ. **öri siri darumui,**

ДГ. **...egelilen daruyu**

ЦГ. **...igelekü γuyuqui-bar ülü amurayulqu,**

СР. **...egelelen qayirala kemen γuyuqui-bar**

ülü amurayulayu,

275. **ularin ...egelegsen čimeg**

275. **aqsuqsan čimeq**

275. **...igelegsen čimeg**

275. **...igelegsen čimeg**

275. **...igelegsen čimeg**

Бадгийн төвөд эхийн утга нь *мэргэн хүн эд баялаг элбэгтэй газар сууна. Учир нь бусад хүн түүнд нэмэр хандив өгдөггүй юмаа гэхэд буй эд хөрөнгийг булааж,*

хулгайлж авахгүй. Эд баялаг хомс, ядуу буурай орныг тэвчих зохистой. Тийм газар суувал буй эд хөрөнгөөс нь булааж, хулгайлахгүй юмаа гэхэд өр зээл, гуйлга тасрахгүй гэсэн санаа юм. Төвөд хэлний *brnya skyis 'joms* хэмээхийг орчуулагчид хэрхэн буулгасан нь сонирхолтой байна. Уг үгийг үгчилбэл “зээлээр дарах” гэсэн утгатай. Төвөд хэлний толь бичгүүдэд *brnya*-г “зээлэх, булаах”, *'joms*-г “дарах, эвдэх, баллах” гэсэн буй.

Үүнийг Сономгара *aysuyad barayu* гэжээ. “*aysu-*” гэдэг үгийг “Хорин наймт тайлбар толь”-д: *Мөнгө зоос ба элдэв юмыг бусдаас түр зээлэн хэрэглэхийг агсан хэмээмүй. Бусдаас хөлстэй мөнгө зоос зээлэн хэрэглэх буюу аливаа юмыг түр авч хэрэглэхийг агсан авмуй хэмээмүй* (Намжилмаа 1994: 45), “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д: *Хүү үржүүлэн бусдаас мөнгө юм авах зээл* (2007:1.36) гэж тодорхой тайлбарлажээ.

Зээлэх хэмээх утгатай “*aysuqu*” гэдэг үг орчин цагийн монгол хэлэнд уг утгаараа төдийлөн хэрэглэгдэхээ больж хуучирсан боловч монгол хэлэнд эдүгээ хүртэл үндсэн утгаа хадгалан хэрэглэгдсээр байна.(1989:412) Сономгара-гийн орчуулгад хоёр, Зая бандидын орчуулгад нэг, нийт гурван удаа тохиолдоход “зээлэх” гэсэн утгыг илтгэсэн төвөд үгтэйгээ утга дүйж байна. Чингэвэл энд *aysuyad barayu* гэдэг бол буй эд баялгийг нь өр зээлээр гуйж аваад дуусгана гэсэн санаа ажээ.

Зая бандида уул төвөд хэллэгийг *erlige-bēr doroyituulxu* гэж буулгажээ. “*erlige*” гэдэг бол “эрэх, гуйх” гэсэн үг юм. “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д: *Эрэх үйлийн нэр, гуйлга* (2007:5.584) хэмээсэн буй. Үүнээс харахад Зая бандида, *эрж гуйсаар эд баялгийг нь багасгаж бууруулна* хэмээсэн санаа илтгэсэн байна.

Мэргэн гэгээн *öri siri darumui* гэж хоршоо үгээр оноожээ. “Хорин наймт тайлбар толь”-д: *Аливаа хүн худалдаа арилжаа гүйлгээ бусдаас урьдчилан агсан авч харилцан өгч авах юмыг өр шир хэмээмүй* (Намжилмаа 1994:443) гэсэн байх бөгөөд энэ нь “зээлэх”-ээс арай тодорхой утгыг илэрхийлнэ.

Дана-гийн гэгээн *...egelilen daruyu* гэсэн нь илүү тодорхой, эрчимтэй утгыг илтгэнэ. “Зээлэх” гэдэг үгийн тухайд “Хорин наймт тайлбар толь”-д: *Өдөр, сарын хугацаагаар хөлс хэлэлцэж мөнгө зоос зээлүүлэхийг зээл тавимуй хэмээмүй. Аливаа юмыг бусдаас агсан хэрэглэхийг зээлмүй хэмээмүй. Бас агсан авмуй хэмээмүй* (Намжилмаа 1994:1875) гэж тайлбарлажээ.

Цахар гэвш *...igelekü yuyuqui-bar ülü amarayulqu* хэмээн үйлийн ерөнхий өрнөлөөр орчуулсан бол Сумадираднаа *...egelelen qayirala kemen yiyuqui-bar ülü amarayulayu* хэмээн үйлийн өрнөлийг тайлбарлах байдлаар орчуулжээ.

Чингэхлээр “*aysu-*” хэмээх үг дундад үеийн монгол хэлэнд хэрэглэгдэж байгаад “зээлэх” гэдэг үгэнд шахагдан, эдүгээ ярианы хэлэнд хэрэглэгдэхээ больсон бололтой. “Зээл-” хэмээх үг түрүү үеийн бичгийн дурсгалуудад үгүй бөгөөд хожуу хятад хэлнээс нэвтэрсэн болох нь ХҮШ зууны үеийн Мэргэн гэгээний орчуулгад эхлэн гарч буйгаас харагдана.

Галиг	Дав- тамж	Төвөд	Соном- гара	Зая бандида	Мэргэн гэгээн	Дана гэгээн	Цахар гэвш	Сумади- раднаа
<i>aysu-</i>	3	<i>g-yar ba, brnya skyis</i>	2	1	-	-	-	-
<i>jigele-</i>	8	<i>g-yar ba, brnya skyis</i>	-	-	1	2	3	2

Ийнхүү ойролцоо үг хэллэг тус бүрийн утгын өнгө аясын онцлог ялгаа илрэхийн зэрэгцээ “*aysu*” хэмээх үг дундад үеийн монгол хэлэнд хэрэглэгдэж байгаад “зээлэх” гэдэг үгэнд шахагдсан нь ажиглагдаж байна. Энэ мэтчилэн уугал үг харь үгтэй холбоо үгийн хүрээнд ойролцоо үг үүсэж буйг жишээлбэл:

(*gros la ‘tshogs*) *ey-e-dür čiyulbasu, zöblöküye čuulxulā, jöbleldür-e čuylabasu, qubilaqui-dur orulčabasu, quubilaqui-dur orulčabasu* гэх мэт.

7. Харь үг харь үгтэй:

Хэдэн зууныг өртөөлсөн эдгээр орчуулгын хэлийг цуваа цагийн үүднээс ажиглахад үгийн утгын хувьсал, хэрэглээг тодруулахын сацуу түүх соёлын харилцааг ч илрүүлэх олон сонирхолтой баримт гарна. Жишээлээд “санах” хэмээх үг болон түүний ойролцоо утгат үгсийн тухай өгүүлбэл, “санах” гэдэг уг үг түрэг хэлнээс гаралтай бөгөөд үндсэн утга нь “тооцох, тоолох” (1969:483), (2003:156) утгатай байж, дундад эртний монгол хэлэнд тэрхүү утгаараа хэрэглэгдэж байсан ч төдийлөн идэвхтэй хэрэглээний үг бус байжээ. (Дэмчигмаа 2013:48) Хожуу үес идэвхтэй хэрэглээнд орсон төдийгүй чингэхдээ үндсэн утгаараа бус одоогийн “бодох, дурдах”-тай адил утгатай болж, хувьсан өөрчлөгдсөн байна. Уг үгийн язгуур “Субашид”-ын орчуулгуудад 166 удаа тохиолдохоос Сономгара-гийн орчуулгад нэг, Зая бандидынхад 11, Мэргэн гэгээнийхэд 18, Цахар гэвшийнхэд 74, Сумадираднаагийн орчуулгад 46 удаагийн давтамжтай. Сономгара-гийн орчуулгын 96 дугаар бадагт гагц удаа гарахад “*rtsis ‘debs -тооцох, тоолон үзэх*” хэмээх утгыг илэрхийлж бусад орчуулгад эдүгээх утгаараа тохиолдож буй. “сана-” МНТ-нд тохиолдохгүй бөгөөд харин “сэтгэх” 80 гаруй удаа, сонгодог монгол бичгийн хэлний өмнөх үеийн дурсгалуудад 130 гаруй удаа тохиолдож байна. Энэ мэтчилэн харь гаралтай үгс хоорондоо болон уугал үгтэй ойролцоо утга үүсгэж буй хийгээд харь үгийн утга хувьсан өөрчлөгдсөн төдийгүй идэвхтэй хэрэглэгдэх болж, уугал үгийн утга явцууран хэрэглээ нь буурсан байдал ажиглагдана.

96. *sdar ma gros byed tshe na dpa’*

khral bskos pa na nor rtsis ‘debs

СГ.(3.11a) *ayuliqai kümün eyetüküi-dür bayaturqayu*

alban kürbesü ed-iyen sanayu

ЗБ. *ayimtayai zöblön üyiledküi caqtu bātar*

alba tusxui-du ed tōlon üyiledküi

МГ. *ayumtayai bögetele jöbleküi-dür bayatur*

alban kereg tusqaqui-dur ün-e bodun orusiγči

ЦГ. *angq-a jöblen kelelčeküi čay-tur yekel-e bayatur metü dürimlekü*

alba tataburi irekü čay-tur bey-e-ečegen ülü γaryaqui-yin ary-a erikü

Дундад эртний монгол хэлэнд одоогийн «санах» гэдэг энэ үгийн оронд «сэтгэх» хэмээх уугал үг өргөн хүрээнд хэрэглэгдэж байгаад аажмаар шахагдан утгын хүрээ нь явцуурсан ажээ. «Санах»-тай ойролцоо утгатай өөр нэгэн үг бол манж хэлнээс гаралтай «бодох» хэмээх үг бөгөөд мөн хожуу 18 дугаар зууны үеэс монгол хэлэнд орж, улмаар идэвхтэй хэрэглэгдэх болсныг үгийн давтамжид үндэслэн харж болно.

Хүснэгт 3. сана-, сэтгэ-, бод-

Үг	Галиг	Төвөд	Дав-тамж	Соном-гара	Зая бандида	Мэргэн гэгээн	Дана гэгээн	Цахар гэвш	Сумади-раднаа
сана-	sana-	bsam pa sems pa	166	1	11	18	16	74	46
сэтгэ-	sedki-		127	28	17	39	40	0	3
бод-	bodu-		98	-	-	2	2	55	39

“Бод-“ гэдэг үгийн талаар мөшгөн үзвэл, манж хэлнээс монгол хэлнээ нэлээд хожуу нэвтэрч, эдүгээ үгийн сангийн идэвхтэй, түгээмэл хэрэглээний үг болсон болсон байна. Зарим эрдэмтэн, эрт монгол хэлнээс түрэг болон бусад төрөл хэлэнд орсон буюу дундын үг (Willian Rozycki 1994:52) хэмээн үзжээ. Гэтэл энэ үг дундад үеийн монгол хэлний бичгийн дурсгалуудад огт тохиолдохгүй, харин “сэтгэх” хэмээх үг л хэрэглэгдэж байсан байх юм. Тухайлбал, “Монголын нууц товчоо”-нд “sedki-” гэдэг үг 80 гаруй удаа тохиолдож байхад “bodu-” гэх үг огт байхгүй ажээ. Чингэвэл “bodu-” хэмээх үг хэдий үед монгол хэлнээ түгээмэл хэрэглэгдэх болсон байж болох вэ?. Үүнийг тодруулахын тулд “Субашид”³-ын монгол орчуулгуудаас лавлан харахад (хүснэгт) “bodu-” язгуурт үг 98 удаа давтагдаж буйгаас Сономгара, Зая бандида Намхайжамц нарын орчуулгад огт байхгүй бөгөөд 18 дугаар зууны дунд үеийн Мэргэн гэгээний орчуулга болон хожим Дана-гийн гэгээний хянан засварлаж 1889 онд барласан орчуулгад тус бүр 2 удаа, Цахар гэвшийн орчуулга (1778-1779)-д 55, Сумадираднаа-гийн орчуулга (19 дүгээр зууны сүүл)-д 39 удаа тохиолдоно. Энэ нь уг үг 18 дугаар зууны дунд үеэс монгол хэлэнд нэвтэрч, сүүл үе гэхэд идэвхтэй хэрэглэгдэх болсныг харуулж байна.

Түрүү үеийн бичгийн дурсгалуудад уламжилж ирээгүй “bodo-” язгуурт үг хожуу үеийн бичгийн дурсгалууд хийгээд манж монгол хэлний толь бичгүүдэд олон байх ажээ. Жишээлбэл: “Таван хэлний толь”-д:

Ma.bodobumbi	Mo. boduyulumui
Ma.bodoyon	Mo. boduly-a
Ma.bodohongyo	Mo. bodulyatai
Ma.bodombi	Mo. bodumui

³ Санскрит товч нэрээр “Subhāṣita”, монголоор “*Сайн номлол эрдэнийн сан*” хэмээх, 457 бадаг бүхий сургаалын зохиолыг Төвөдийн алдарт эрдэмтэн Сажа бандид Гунгаажалцан /1182-1251/ төвөд хэлээр зохиосон бөгөөд энэхүү зохиол монгол хэлнээ олон удаа дараалан орчуулагдсанаас XIII зууны сүүлчээс XIX сүүл үеийг хамарсан бичгийн найман орчуулга эдүгээ бидэнд мэдэгдээд байгаа билээ. Үүний зэрэгцээ манж орчуулга бас буй бөгөөд эхний дөрвөн бүлгийг төвөд, манж, монголоор хадмалласан эх Буриадын Шинжлэх Ухааны Төвийн номын санд хадгалагдаж байна.

Ma.bodon

Mo. *bodul*

Ma.bodonumbi

Mo. *bodulčamui* (1957:) зэрэг нэлээд үг буй.

Түүнчлэн эвенк, солон, ороки, орочи, нанай хэл аялгуунуудад ижил “bodo-, budu-” язгууртай (Willian Rozycki 1994:2) байх юм. Дээрх жишээ баримтуудад тулгуурлан эл үгийг манж, тунгус хэлнээс гаралтай хэмээн үзэж болмоор байна. Хэрэв монгол хэлний уугал үг бол эрт үеийн бичгийн дурсгалуудад эрхбиш хадгалагдан үлдэх нь лавтай. Эл санаа мөн “Субашид”-ын 67, 148 дүгээр бадгуудаас тодорхой харагдана.

67. rtag tu gzhan don mi sems pa

de yi spyod pa phyugs dang mtshungs

СГ. nasu busud-un tusa-a ülü *sedkigčün-ü* aburi inu
adaγusun-dur adali bolai

ЗБ. nasuda busudiyin tusa ülü *sanaqči*
töüni yabudal adousun-luy-a adali

МГ.ürgül...ide činadusun tusa ülü *sedkigči*-yin
yabudal-un yosun anu aduyusun adali

ЦГ. nasuda busud-tur tusa ügei ...üg amiban *boduyči*
narin qargis kümün-ü yabudal mal-luy-a adali

СР. nasuda busud-un tusa-yi ülü *boduyči*

nasuda ami-ban boduyči kümün-ü yabudal mal-luy-a adali

148. yid la bsam pa gzhan byas nas

СГ. sedkil-degen busu-yi *sedkijü*

ЗБ. sedkildü busu *sanā sanan*

МГ.sedkil-tegen busu nigen *sanayan-i sedkijü*

ЦГ. ünen sanayan-dayan öber-e nigen-i *boduyad*

СР. ünen sanayan-dayan öber-e nigen-i *boduyad*

Ийнхүү эх зохиолын нэг үгээс уугал болон харь хэлний гаралтай, ойролцоо утгат хэд хэдэн үг үүсэхийн зэрэгцээ эдгээр нь олон талын баримт болж байгаагаараа судалгаа шинжилгээний ихээхэн ач холбогдолтой юм.

Дээр дурдсан үгсэд орсон холбоо үг ойролцоо утга үүсгэж буйг жишээлэн үзвэл:

22. blo dang ldan na ma smras kyang

rnam ‘gyur nyid las bsam pa go

СГ.uqayatu bolbasu ögülekü-yin urida böged
aburibar kü *sedkil-i inu uqayu*

ЗБ. oyoun tögöskülē ese ögüülebeči
šingši bayidal-yēr *sanān medekü*

МГ. uqayatan ese ögülebečü
aγali-bar *sanayan-i medemü.*

ЦГ. boduly-a uqayan sayin bolbasu ese kelelčibečü
busud-un dūri bayidal-iyar *sanay-a-yi inu medemüi* y-a

СР. boduly-a uqayan sayin bolbasu ese kelelčibečü
busud-un dūri bayidal-iyar *sanay-a-yi anu medemüi.*

Төвөд эхийн утга нь: *оюун төгөлдөр хүн болбоос бусад хүнийг хэлээгүй байхад гаднах царай, дүр байдлаас нь бодол санааг ойлгоно.*

Эл бадаг дахь *bsam pa go* хэмээх төвөд үгийг Сономгара *sedkil-i inu uqayu* гэж буулгасан бол бусад орчуулагчид “санааг мэдэх” гэсэн ажээ. “Сэтгэл” гэдэг бол хүний төрөлх дотоод гүн нарийн мэдрэмж, илэрхийлэл бөгөөд “санаа” бол түүнээс урган гарах зүглэл билээ. “Ухах” хэмээхийг Норжины “Монгол хэлний толь”-д: *Хэрэг бодсын өнгөн үзэгдэлд торохгүйгээр цаад зүй ёсыг гүн ойлгож мэдэх* (Norjin 1994: 466), “мэдэх”-ийг *хэрэг явдлын өнгөрөлтийг үзэж сонссон байх* (Norjin 1994:1831) гэж тайлжээ. Тиймийн тул “сэтгэлийг ухах” гэдэг нь маш гүн гүнзгий, нарийн утгыг агуулах бөгөөд “санааг мэдэх” гэдэг бол ерөнхий өнгөн утгыг илэрхийлэх юм. Ерөөс дундад эртний монгол хэлэнд “ухах” гэдэг үгийг өргөн хэрэглэж байсан бололтой байдаг.

8. *Хэлц үг хэлц үгтэй буюу ойролцоо хэлц:*

tngri dongyud-. (211. *‘brug sgra sgrogs*). “**dongyud-**” гэдэг үг эрт үедээ 1. Дуугарах, өгүүлэх, 2. Зэмлэх буруушаах, 3. Шувуу жиргэх, 4. Аянга, тэнгэр дуугарах (Rachewilts 1972:796) гэх зэрэг утгыг зааж байсан бөгөөд орчин цагийн монгол хэлнээ “*дуугарах, өгүүлэх, тэнгэр дуугарах*” утга хэрэглэгдэхээ больж явцуурчээ. Ялангуяа “МНТ”-нд *дуугарах, өгүүлэх, зэмлэх буруушаах* утгаар хэдэнтээ гарч буй. Уг хэлцийг орчуулагч нар хэрхэн оноосныг 211 дүгээр бадгаас жишээлбэл:

СГ. tngri dongyuduyu

ЗБ. kluyin dou dourisxaxu

МГ, ДГ. luus-un dayun γaryamui

ЦГ. luu-yin dayun dayurisqu metü

СР. luu-yin dayun dayurisqam

хэмээнээс “*тэнгэр донгодох, лусын дуун дуурсгах, лусын дуун гарах, луугийн дуун дуурсах*” гэх ойролцоо хэлц үүсэж байна. Төвөд эхийн утга нь “*луугийн дуун дуурсах*” буюу *тэнгэр дуугарах, аянга цахих* гэсэн утгатай бөгөөд Сономгара уугал үгээр, Зая бандида “*klu-лус*” гэдэг төвөд үгээр, Мэргэн гэгээн, Дана-гийн гэгээн нар мөн лус гэж монголжсон дуудлагаар, Цахар гэвш, Сумадираднаа нар “*луу*” гэж хятадажсан дуудлагаар тус тус оноон буулгасан нь монгол хэлний түүхэн хөгжлийн дүн дэх түүх соёлын онцлогийг тусгасан баримт болно.

Ийнхүү орчуулгууд нь үгийн сангийн ойролцоо утгат үгсийг үүсгэхийн сацуу зарим үгсийн утгын хувьсал хийгээд түүхэн онцлогийг харуулж байна. “Субашид” томоохон хэмжээтэй зохиол учраас үгийн сангийн тухайд ихээхэн сонирхолтой бөгөөд баялаг хэрэглэгдэхүүн билээ. Мөнхүү олон орчуулгын дүнд үүсэж буй эдгээр ойролцоо үг бол монгол хэлний үгийн сан болон найруулгын хувьд чамгүй ач холбогдолтой юм. Энэхүү өгүүлэлд цөөн тооны жишээг дурдахад ийм буюу.

Товчилсон үг

СГ Сономгара
ЗБ Зая бандида Намхайжамц
МГМэргэн гэгээн Лувсандамбийжалцан
ЦГ Цахар гэвш Лувсанчүлтэм
СР Сумадираднаа

Ном зүй

Монгол хэлээр:

- Болд нар. (2005). *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь*. Улаанбаатар.
- Böke nar (1986). *Dungsiyang kelen-ü üge kelege-yin materiial. Öbür mongγul-un arad-un keblel-ün qoriy-a.*
- Монгол хэл судлал. (2022). *Үгийн сан, утга зүй*. Улаанбаатар.
- Дэмчигмаа, О. (2013a). *Субашидын монгол орчуулгуудын үгийн сангийн онцлог*. Удам соёл. Улаанбаатар.
- Дэмчигмаа, О. (2013b). *Субашидын монгол орчуулгуудын үгийн сангийн судалгаа*. Докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол. Улаанбаатар.
- Norjin, Ї, Mai Mören. (1994). *Mongγul kelen-ü toli. Öbür mongγul-un arad-un keblel-ün qoriy-a.*
- Namjilm-a. (эмх.). (1994). *Qorin naimatu tailburi toli. Öbür mongγul-un arad-un keblel-ün qoriy-a.*
- Сайн үгт эрдэнийн сан нэрт шастур*. (1989). Зууннаст, Сэцэнцогт харгуулан тайлбарлав. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн хороо.
- Tabun jüyil-ün üsusg-iyer qabsuruyсан manju ügen-ü toli bičig.* (1957). Begejing. *Ündüsüten-ü keblel-ün qoriy-a.*
- Цэвэл, Я. (1996). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар.
- Čenggeltei (1988). *Mongur kelen-ü üge kelege-yin materiial. Öbür mongγul-un arad-un keblel-ün qoriy-a.*
- Чоймаа, Ш. (2003). *Монгол судлалын өгүүлүүд*. Улаанбаатар.
- Engkebatu.(1985). *Daγur kelen-ü üge kelege-yin materiial. Öbür mongγul-un arad-un keblel-ün qoriy-a.*

Англи хэлээр:

- Igor De Rachewilts. (1972). *Index to the Secret History of the Mongols*. Indiana University. Bloomington.
- Tumurtogoo D. (2006). *Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XIII-XVI centuries) // Introduction, Transcription and Bibliography Linguistics Monographs Series A 11], Academia Sinica, Institute of Linguistics, Taipei, Taiwan.*
- Willian Rozycki. (1954). *Mongol elements in Manchu*. Indiana University Uralic and Altaic, Vol.157.

Орос хэлээр:

- Наделяев В.М, Насилов Д.М, Тенишев Э.Р, Щербак А.М. (ред). (1969). *Древнетюркский словарь*. Ленинград. Издательство “НАУКА”.

Төвөд хэлээр:

Sumatiradna. (1959). *Bod-Hor gyi brda yig min tshig don gsum gsal bar byed pa mun sel skron me*.

Redactor. p. Prof. B. Rinchen. Corpus Scriptorum Mongolorum. Tomus VI, VII. Ulaanbaatar.

Герман хэлээр:

Erich Haenisch. (1959). *Mongolica der Turfan-Sammlung*. Berlin. 1959.

Abstract

Different types of translation of the same textwork are the basic fundamentals of the synonym formation.

The synonyms, one of the basic units of lexicology, express not only the nuances of the meaning but also play a crucial role in making the composition appropriate, meaningful, and eloquent. The synonyms can form in several ways, and here we tried to study the formation of the synonyms based on the several translations of “Subhashita” 1. Honourable word + ordinary word, 2. Written language word+ dialect word, 3. Synonym (mngon brjod ming) + ordinary word, 4. Archaic and historic words + new words, 5. Indigenous word + indigenous word, 6. Indigenous word + foreign word, 7. foreign word + foreign word, 8. idioms + idioms within the framework of the several different translations of the same work. During the research, while explaining some archaic and historic words, the origins of foreign words, the evolution of the meaning, and the usage with specific examples, we clarified from other sources, written monuments, and related dictionaries.